

□  
**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН  
ҮЙЛДВЭРИЙН САЙД, ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ**

2022 оны 02 дугаар сарын 09–ний өдөр

Дугаар A/25, A/46,A/75

Улаанбаатар хот

**ЖАГСААЛТ БАТЛАХ ТУХАЙ**

Химиин хорт болон аюултай бодисын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

- 1.Монгол Улсад 2022 онд хөдөө аж ахуйд ургамал хамгааллын зориулалтаар ашиглаж болох пестицидийн жагсаалт, тоо хэмжээг 1 дүгээр, газар тариалангийн зориулалтаар ашиглаж болох химиин бордооны жагсаалт, тоо хэмжээг 2 дугаар, мал эмнэлгийн ариутгал, халдвартгүйтгэлийн зориулалтаар ашиглаж болох бодисын жагсаалт, тоо хэмжээг 3 дугаар, ахуйн хортон шавж, мэрэгч устгалын болон ариутгал, халдвартгүйтгэлийн зориулалтаар ашиглаж болох бодисын жагсаалт, тоо хэмжээг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.
- 2.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга нарт тус тус үүрэг болгосугай.
- 3.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан "Жагсаалт батлах тухай" Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2021 оны A/52, A-42, A/71 дүгээр хамтарсан тушаалыг хүчингүйд тооцсугай.

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛЫН САЙД**

Б.БАТ-ЭРДЭНЭ

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН  
ҮЙЛДВЭРИЙН САЙД**

3.МЭНДСАЙХАН

**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД**

С.ЭНХБОЛД